



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/61

Мандалговь

**Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны
шторк бэлтгүүлэх тухай**

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.1.4, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.1.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Сүүдэр бүү тусга" аяны хүрээнд иргэдэд зориулсан шторк хийлгэж, олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагааг зохион байгуулсугай.
2. Үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Шаардагдах 1 300 000 (Нэг сая гурван зуун мянга) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Р.Мөнхбат), гишүүдэд үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Р.Мөнхбат)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

491190113